



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2020 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 73

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Амгалан дулааны станц” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 30,000,000.00 (гучин сая) төгрөгийн балансын үнэ, 22,054,508.87 (хорин хоёр сая тавин дөрвөн мянга таван зуун найман төгрөг наян долоон мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан 1 ширхэг автомашиныг Хил хамгаалах өрөнхий газар (Хилийн анги)-т балансаас балансад шилжүүлсүгэй.

2. “Амгалан дулааны станц” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Ш.Баянмөнх, Хил хамгаалах өрөнхий газрын дарга, бригадын генерал Ж.Бямбасүрэн нарт дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай

ДАРГА

3.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ *Д.Нарангэрэл* Д.НАРАНГЭРЭЛ

0000113

Төрийн ёмчийн бодлого зохицуулалтын газрын
2020 оны 22 дугаар сарын 22-ны өдрийн
22 дугаар тогтоолын хавсралт

"АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ" ХЯЗГААРЛАГДМАЛ ХУВЬЦААТ КОМПЛИИАС ХИЛ ХАМГАЛДАХ ЕРӨНХИЙ ГАЗАРТ БАЛАНСААС
БАЛАНСАД ШИЛЖКҮҮЛЭХ АВТОМАШИН

Д/д	Автомашины марк, улсын дугаар, аралын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ (төгрөг)	Хурумтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Төёото Хариер, 78-07 УНИ, ACU350003291	2003/2011	Ш	1.00	30,000,000.00	22,054,508.87	7,945,491.13
					30,000,000.00	22,054,508.87	7,945,491.13

Нийт дүн
(гучин сая)

(хорин хоёр сая тавин
дөрвөн мянга таван
зуун найман төгрөг
наян долоон мянгэ)

(долоон сая есөн
зуун дөчин таван
мянга дөрвөн зуун
өрэн нэгэн төгрөг
арван турван мэнгэ)